



**ХӨВСГӨЛ АЙМГИЙН
ЦАГААН-УУЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 10 сарын 17 өдөр

Дугаар А/155

Цагаан-Уул сум

Г Хяналт тавих комисс томилох тухай Г

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1, 47 дугаар зүйлийн 47.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:


1. 2024 онд Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар хийгдэх Арьс шир, дайвар бүтээгдэхүүн боловсруулах үйлдвэрийн хашаа барих ажилд хяналт тавих комиссыг дараах бүрэлдэхүүнтэйгээр томилсугай.

Ахлагч: Д.Мөнхбат (Татварын Улсын байцаагч)

Гишүүдэд : Ж.Бадрал (Архив, бичиг хэргийн ажилтан)

Нарийн бичгийн дарга: М.Оюунчимэг (Хөдөө аж ахуйн тасгийн мэргэжилтэн)

2. Техникийн тодорхойлолтын дагуу дээрх ажилд хяналт тавьж тэмдэглэл хөтлөж, акт үйлдэж ажиллахыг хяналт тавих комисс (Д.Мөнхбат)-д үүрэг болгосугай.

ДАРГА  С.ГОНЧИГНЯМ

/Zahiramj 2024/